

## АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Иргэний нисэхийн ерөнхий газар

2023 оны жилийн эцэс

Д/Д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
<b>1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх</b>								
1		1.1.АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон	2023 он	-Баримтжуулсан байх  -Үр дүнг тооцож, тайлагнасан байх. (түгээсэн тоо, давтамж, авсан хандалтын тоо)  -Харьяа газар, нэгжүүдийг хамруулсан байх.		-	Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс бэлтгэн гаргасан богино хэмжээний бичлэгүүдийг ИНЕГ, түүний харьяа алба салбар, нэгжийн цахим сайтуудад байршуулсан. Үүнд: “Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогыг 2023.02.15-ны дотор мэдүүлэх заавар” богино хэмжээний бичлэгийг 2023.01.18-ны өдөр ИНЕГ-ын цахим хуудсанд, “Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хэрхэн мэдүүлэх зөвлөгөө” богино хэмжээний бичлэгийг 2023.01.25-ны өдөр ИНЕГ-ын цахим хуудсанд, “Авлигын гэмт хэрэг” №2, №3 богино хэмжээний бичлэгийг 2023.06.19-ний өдөр ИНЕГ-ын цахим хуудсанд, “Иргэд ээ, албан тушаалтнууд аа анхаарна уу” богино хэмжээний бичлэгийг “Буянт-Ухаа” олон улсын нисэх буудлын ажилтнуудын цахим группт 2023.05.17-ны өдөр, “Алдагдах шахсан монголын баялаг” богино хэмжээний бичлэгийг Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны сайтад 2023.04.30-ны өдөр, “Үгүй гэж хэлээд өөрчилье” богино хэмжээний бичлэгийг 373 гишүүнтэй “Avsec Mongolia” фэйсбүүк групп, АБХА-ны “Шуурхай үүрэг даалгавар” цахим группт, “Үйлийн үр хаяг андуурдаггүй юм” богино	100%

		нийтэд хүргэсэн байх;				хэмжээний бичлэгийг Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албаны төв байрны нэгдүгээр давхарт байрлах сурталчилгааны дэлгэцэд 2023.03.23-24-нд, “Зөв зөвд шударга зөв” богино хэмжээний бичлэгийг Нислэгийн удирдлагын урсгал төлөвлөлтийн албаны atfm.mcaa.gov.mn цахим хуудсанд, “Түүний түүх бүтээлийн уралдаан” богино хэмжээний бичлэгийг “Отгонтэнгэр” нисэх буудлын албан ёсны цахим хаяг фейсбүүк пэйж хуудсанд, “Шүгэл үлээгч” богино хэмжээний бичлэгийг “Ховд” нисэх буудлын албан ёсны цахим хаяг фейсбүүк пейж хуудсанд 2023.03.22-ны өдөр, “Авлигын хор хөнөөл” “Авлигын гэмт хэрэг №3” богино хэмжээний бичлэгийг “Арвайхээр” нисэх буудлын нийт ажилчдын цахим группт 2023.03.24-ний өдөр, “Авлигын эсрэг нэгдье” богино хэмжээний бичлэгийг тус тус байршуулсан. Нийтдээ давхардсан тоогоор 2797 ажилтан мэдээлэлтэй танилцсан.  Хавсралт : 2 файл	
2		1.2.Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг дэвсгэрийн нэгж, байгууллага, салбарын онцлогт тохируулан зохион байгуулах;	2023 он	-2-оос доошгүй өдөрлөг, нөлөөллийн үйл ажиллагаа г.м соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх;	0.6	Мэдээллийн цаг арга хэмжээгээр 3 удаа авлигатай тэмцэх талаар мэдээлэл өгөх, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 578 ажилтан хамрагдсан. Үүнд: “Авлига, албан тушаалын гэмт хэрэг болон цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сэдвээр 2023.04.21-ний өдөр Нийслэлийн прокурорын газар, “Буянт-Ухаа” олон улсын нисэх буудалтай хамтран; •“Авлигын шалтгаан, нөхцөл, үр дагавар, авлигаас урьдчилан сэргийлэх арга зам” сэдвээр 2023.07.28-ны өдөр “Засаглал судлалын хүрээлэн” ТББ-ын гүйцэтгэх захирал, судлаач Ш.Зулцэцэг; •“Төрийн албан хаагчийн ёс зүй, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах нь”сэдвээр 2023.09.06-ны өдөр. Авлигын	100%

				-Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргасан байх.		эсрэг хуульд заасан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах 2 сургагч багшийг бэлтгүүлж, гэрчилгээжсэн. Сургагч багш нар сургалтын материал боловсруулж, 2023.11.08-нд ХНАА-нд сургалт зохион байгуулж, 63 ажилтан танхимаар, 12 ажилтан цахимаар хамрагдсан. Мөн “Авлигын тухай ойлголт, авлигаас урьдчилан сэргийлэх нь” сэдвээр 2023.11.06-нд АБХА-нд сургалт зохион байгуулж, 13 ажилтан танхимаар, 140 ажилтан цахимаар хамрагдсан.Авлигатай тэмцэх газраас 2023 оны 06 дугаар сард санаачлан эхлүүлсэн “НЭГДЬЕ” аянд нэгдэх зарыг IMCAA-д байршуулж, ХНАА-ны хамт олон нэгдэж, аяны үйл ажиллагаа, зурагт танилцуулгуудыг байгууллагын албан ёсны цахим вэб хуудас (Холбоо, навигаци, ажиглалтын алба) болон нийгмийн сүлжээ болох фейсбүүк (Холбоо, Навигаци, Ажиглалтын Алба), viber групп (ХНАА Алба) албаны дотоод e-mail хаяг (cns@mcaa.gov.mn) зэрэгт байршуулж, сурталчилсан.	
3	1.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах;	2023 он	-Мэдээллийг сар бүр шинэчлэх;  -Тайланд сар бүр шинэчилсэн нотломжийг хавсаргасан байх.	-	“Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбарт байршуулах мэдээллийг өөрсдийн нөөц боломжид тулгуурлан бэлтгэж, 2023 оны 3,4,6,7,8,9,10,11,12 сард мэдээллийг байршуулсан.	100%	
					Хавсралт нийт : 8 Файл : 5 Зураг : 3		
					Хавсралт : 9 зураг		

4		<p>1.4. Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, броюшур зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд хүргэсэн байх.</p>	<p>-2-оос доошгүй сурталчилгааны материал боловсруулсан байх;</p> <p>-Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх;</p> <p>Авлигыг мэдээлэх 110 дугаарыг</p>		-	<p>Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий 1 зурагт хуудас, 1 шторкийг хийж, байгууллагын цахим хуудсанд, мэдээллийн самбарт, сурталчилгааны самбарт болон пейз хуудсанд байршуулж, олон нийтэд хүргэсэн.</p> <p>Хавсралт нийт : 2 Файл : 1 Зураг : 1</p>	100%
---	--	---	---	--	---	--	------

				оруулсан байх.				
<b>2. Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах</b>								
5		2.1.Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх;	2023 он	-Шинэ томилогдсон албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байх;  -Тайланд нотломжийг хавсаргасан байх.		0.2	Авлигатай тэмцэх газартай хамтран “Авлигын хор уршиг, авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга” болон “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалтыг 2023.11.30-ны өдөр зохион байгуулж, танхимаар 98, цахимаар 100 ажилтан хамрагдсан. “Төрийн албан хаагчийн ёс зүй, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах нь”сэдэвт сургалтыг 2023.09.06-ны өдөр зохион байгуулж, тус сургалтад Иргэний нисэхийн ерөнхий газар, Иргэний нисэхийн үндэсний төв, орон нутгийн нисэх буудлуудын албан хаагчид танхимаар /40/ болон цахимаар /zoom 40/ хамрагдсан. Сургалтыг хуульч, судлаач О.Мөнхцэцэг хийсэн.  Хавсралт нийт : 4 Файл : 3 Зураг : 1	100%
6		2.2.Тухайн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг (тухайлбал, тусгай зөвшөөрөл эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хамтран	2023 он	-Өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулсан байх;  -Тайланд нотломжийг		-	Тус байгууллагын үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг тусгай зөвшөөрөл олгох программ хангамжийг үйл ажиллагаандаа мөрдөж эхлэхээр зохион байгуулахаар төлөвлөж байсан боловч тусгай зөвшөөрлийг цахимжуулах ажил энэ оны 12 дугаар сард багтаж үйл ажиллагаанд нэвтрэхтэй холбогдуулан арга хэмжээг зохион байгуулах хугацаа хойшилсон. Авлигын эсрэг хуульд заасан авлигаас урьдчилан сэргийлэх, соён	70%

	ажилладаг бизнесийн байгууллага, үйлчилгээ авдаг хуулийн этгээд, иргэн, хяналт, оролцоо хэрэгжүүлдэг ТББ г.м) байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах.		хавсаргасан байх.		гэгээрүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулах 2 сургагч багшийг АТГ-аар бэлтгүүлж, гэрчилгээжсэн. Сургагч багш нар сургалтын материал боловсруулж, 2023.11.08-нд ХНАА-нд сургалт зохион байгуулж, 63 ажилтан танхимаар, 12 ажилтан цахимаар хамрагдсан. Мөн “Авлигын тухай ойлголт, авлигаас урьдчилан сэргийлэх нь” сэдвээр 2023.11.06-нд АБХА-нд сургалт зохион байгуулж, 13 ажилтан танхимаар, 140 ажилтан цахимаар хамрагдсан. Тус байгууллагаас авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2023 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг байгууллагаас эрхлэн гаргадаг Flight сэтгүүлийн 12 дугаар сарын дугаарт байршуулсан. Мөн ИНД дүрмийг шинээр, шинэлэх, нэмэлт өөрчлөлт оруулахдаа нөлөөллийн шинжилгээ хийж, хэлэлцүүлэг зохион байгуулж хэвшсэн.Тухайлбал: 2023 онд ИНД-119 -д нэмэлт, өөрчлөлт оруулахдаа агаарын тээвэрлэгчдийг оролцуулсан хэлэлцүүлгийг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан саналыг дүрмийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгасан.  Хавсралт : 3 файл	
<b>3. Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох</b>						
7	3.1.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг	2023 он	-Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан байх;	-	ИНЕГ-аас гадны байгууллагатай хийх аливаа гэрээ хэлэлцээрийн төсөлд “Ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаар” гэсэн зүйл шинээр нэмж, ашиг сонирхлын зөрчилтэй эсэхтэй холбоотой харилцааг зохицуулсан 5-н заалтыг заавал тусгаж, гэрээг байгуулж байна. <a href="https://www.mcaa.gov.mn">https://www.mcaa.gov.mn</a> цахим сайтад байршуулсан “Үлгэрчилсэн жишиг гэрээний загвар”-т Захиалагч нь	100%

		тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх;		-Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх;  -Гэрээг цуцалсан тохиолдолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг оруулах;  - Хэрэгжилтийн ач холбогдлыг үнэлж, дүгнэсэн байх;  -Тайланд нотломжийг хавсаргасан байх.		“Авлигын эсрэг хууль”-ийн 7 дугаар зүйлийн 7.1.2-7.1.7 дахь хэсэгт заасан үйлдэл, эс үйлдэхүй гаргасан тохиолдолд удирдах албан тушаалтан болон удирдах дээд шатны байгууллагад, хуулийн хариуцлага хүлээлгэхээр бол Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдэгдэх үүрэгтэй гэж, ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй талаараа асуулга бүхий заалтыг болон ашиг сонирхлын зөрчил үүссэн талаар мэдэгдэх зохицуулалтыг тусгасан. Тайлант хугацаанд Иргэний нисэхийн ерөнхий газар гадны байгууллагатай 71 гэрээ байгуулснаас 59 гэрээ он дамжин хэрэгжиж, 12 гэрээний хугацаа дуусаж, гэрээг дүгнэхэд гэрээтэй холбоотой авлига, ашиг сонирхлын зөрчил үүсээгүй байна.  Хавсралт : 3 файл	
8		3.2.“Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх	2023 он	-Олон нийтийн хяналтад хамруулах чиглэлийг тодорхойлсон байх;	-	Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-д заасны дагуу Олон нийтийн хяналтыг хамруулах чиглэлийг тодорхойлон, журмын 2.1.1.Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасан мэдээллийн ил тод, нээлттэй байдал; 2.1.7.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ	70%

	журам"-ыг хэрэгжүүлэх		-Сургалт, мэдээлэл авсан байх;  -Хяналтын чиг үүргийг гүйцэтгүүлэх, тайлан зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлсэн байх.			худалдан авах тухай хуульд заасан олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмын хэрэгжилтийн байдалд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх этгээдээр сонгогдсон Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооны иргэн А.Арвинжаргалтай ажил гүйцэтгүүлэх тухай 67/23 дугаартай гэрээг 2023.11.29-ны өдөр байгуулж, дээрх 2 чиглэлээр олон нийтийн хяналтыг хэрэгжүүлсэн ажлын тайлан, зөвлөмжийг 2023.12.11-ний өдөр хүлээн авсан. Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлсэн байдлыг үнэлсэн тайланд ИНЕГ-ын ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг илтгэх нийт 42 арга хэмжээ 73.7%-ийн биелэлттэй / байгууллагын цахим хуудас шинэчилж байх үед хийсэн/, ИНЕГ-ын 2023 онд байгуулсан үнэлгээний хорооны тушаалууд нь үнэлгээний хорооны гишүүнээр нэг албан тушаалтныг, ялангуяа төрийн бус байгууллагын төлөөллийг олон давтамжтай оруулсан, энэ нь дээрх ТББ-уудын төлөөлөл олон нийтийн оролцоог хангаж ажилладаг эсэхэд эргэлзээ төрүүлэхүйц байгаа, худалдан авах ажиллагаанд жил бүр дотоод аудит, хяналт шалгалт хийдэггүй зэрэг зөрчлүүд байна гэж тусгаж, 6 зөвлөмж ирүүлсэн байна. Тайланг удирдлагад танилцуулж, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах чиглэлээрх арга хэмжээг нэгжүүдийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.  Хавсралт : 1 файл	
<b>4. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах</b>							
9	4.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг	2023 он	-Үйл ажиллагаанд эрсдэлийг		-	Зөвшөөрлийн тухай хуулийн 5.9, 5.10, 5.11 заалтуудад тусгагдсан иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн мэдээллийг "www.license.mn"-д оруулахаар	100%

	бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м/		тодорхойлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх;  -Тайланд нотломжийг хавсаргасан байх ;		өгөгдөл солилцож, туршилтыг хийж байсан боловч 2023 оны 12 дугаар сарын эхээр <a href="http://www.ebusiness.mn">www.ebusiness.mn</a> -д шилжүүлж оруулахаар Цахим хөгжлийн яам шийдвэрлэсэн. Иймд мэдээллийг тус цахим хуудсанд оруулж, 2023 оны 12 дугаар сард үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлэхээр ажиллаж байна. Иргэний нисэхийн салбарын гэрчилгээ, зөвшөөрлийн мэдээллийг Зам, тээврийн хөгжлийн яамны нэгдсэн систем <a href="http://digital.mrtd.gov.mn">/digital.mrtd.gov.mn</a> -д холбож, мэдээлэл шуурхай дамжуулдаг болсон. АТГ-ын 2019 оны А/40 дүгээр тушаалаар баталсан “Авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлал”-ын дагуу 100 ажилтнаас санал асуулга авч, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр тус байгууллагаас авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, санхүүгийн хүндрэлтэй байгаа өнөө үед өөрсдийн нөөц боломжид тулгуурлан байгууллагын авлигын эрсдэлийн үнэлгээ хийж, тайланг удирдлагуудад танилцуулж, баталгаажуулсан.Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан цаашид авах арга хэмжээг тодорхойлж, дунд хугацаанд баримтлах бодлогоо тодорхойлж, ИНЕГ-ын даргын 2023 оны А/386 дугаар тушаалаар баталсан. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу байгууллагын цахим хуудсанд байршуулсан мэдээллийн байдалд дүн шинжилгээ хийж, 88 мэдээллийг байршуулах зохион байгуулалтын арга хэмжээ авсан. Цахим хөгжлийн яамны үнэлгээгээр тус байгууллагын шилэн нээлттэй ил тод байдал 93.1%-тай байна. <a href="https://shilen.gov.mn/">https://shilen.gov.mn/</a>  Хавсралт нийт : 4 Файл : 1 Зураг : 3	
10	4.2.Салбарын хэмжээнд авлигаас	2023 он	-2-оос доошгүйг	-	Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяа Засгийн газраас 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил”	100%

	урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгасан байх;		зохион байгуулсан байх;  -Хэлэлцүүлэг, уулзалтын үр дүнд арга хэмжээ зохион байгуулсан байх;  -Тайланд нотломжийг хавсаргасан байх		болгон зарласантай холбогдуулан ИНЕГ-ын 2023 оны авлигын эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний танилцуулгын 2023.04.27-нд хийсэн. Танхимаар 118, цахимаар 100, лайваар 604, нийт 822 ажилтан хамрагдсан. Уулзалтын үеэр авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх санал, хүсэлтийг сонсож, гарсан санал хүсэлтийг анхаарч ажиллахаа удирдлага мэдэгдсэн.ИНЕГ, түүний харьяа салбар, нэгжүүдийн хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох зорилгоор судалгааг авч, Иргэний нисэхийн ерөнхий газрын авлигын эрсдэлийн үнэлгээг хийж, удирдлагуудад танилцуулж, цаашид авах арга хэмжээг тодорхойлж, ИНЕГ-ын авлигын эсрэг баримтлах хөтөлбөр /2024-2030 он/-ийг боловсруулан, ИНЕГ-ын даргын 2023.12.08-ны өдрийн А/386 дугаар тушаалаар баталсан.  Хавсралт нийт : 4 Файл : 2 Зураг : 2	
11	4.3.Үйлчлүүлэгч-дээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга	2023 он	-Бодитой үр дүнг тооцсон байх;  -Тайланд нотломжийг хавсаргасан байх		Тус байгууллагаас иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээг үзүүлэхдээ хүнд суртал, чирэгдэл, ёс зүйн доголдол гаргаж байгаа эсэхэд тус байгууллага энэ онд судалгаа хийгээгүй бөгөөд харин АТГ-ын захиалгаар "Эс Ай Си Эй" ТББ тус байгууллагад "Шударга байдлын үнэлгээ-2023" судалгааны ажлыг гүйцэтгэсэн. Тус судалгааны ажлын бүрэлдэхүүн хэсэг болох гадаад шударга байдлын үнэлгээг хийхтэй холбогдуулан тус байгууллагаас гэрчилгээжиж байгаа иргэний нисэхийн байгууллага, мэргэжлийн ажилтнуудын жагсаалтыг гаргаж өгсөн. Иргэний нисэхийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлдэг мэргэжлийн байгууллагын онцлогийг тайлбарлаж, иргэдээс авах судалгааг орон нутгийн нисэх буудлаар үйлчлүүлж буй иргэдээс авахыг зөвлөсөн.Тайлан албан	100%

		хэмжээ зохион байгуулах.				ёсоор баталгаажиж ирээгүй байна. Өмнөх онуудад хийсэн шударга байдлын үнэлгээ нь тус байгууллагад тулгамдаж асуудлыг тодорхойлж, цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг тодорхойлоход тус дөхөм болсон. Энэ онд байгууллагын авлигын эрсдэлийн үнэлгээг хийхдээ Шударга байдлын үнэлгээний 2021, 2022 оны тайланг ашиглаж, дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээг тодорхойлсон. НЭМСЗА үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авч, цаашид үйлчилгээгээ сайжруулахад ашиглаж байна.	
Хавсралт нийт : 3 Файл : 2 Зураг : 1							

**5. Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх**

12		5.1.Удирдлагын зүгээс 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2023 оны 1-р улиралд, хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулах;	2023 он	-Танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх;  -Албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг хэлэлцсэн байх;  -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	-	Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяа Засгийн газраас 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарласантай холбогдуулан ИНЕГ-ын 2023 оны авлигын эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон танилцуулгыг 2023.04.27-нд хийсэн. Танхимаар 118, цахимаар 100, лайваар 604, нийт 822 ажилтан хамрагдсан. <a href="https://imcaa.mcaa.gov.mn/news/list?category=1">https://imcaa.mcaa.gov.mn/news/list?category=1</a> танилцуулгын үеэр гаргасан санал, санаачилгыг эрсдэлийн үнэлгээ хийхдээ авч үзснээс гадна ИНЕГ, түүний харьяа салбар, нэгжүүдийн хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох зорилгоор судалгаа авч, судалгаанд тулгуурласан, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр тус байгууллагаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний байдалд дүн шинжилгээ хийж, байгууллагын авлигын эрсдэлийн үнэлгээг өөрсдөө хийж, цаашид авах арга хэмжээг тодорхойлсон "Авлигын эсрэг баримтлах	100%
----	--	--	---------	---	---	---	------

						<p>хөтөлбөр /2024-2030 он/"-ийг боловсруулж, ИНЕГ-ын даргын 2023 оны А/386 дугаар тушаалаар баталсан. ИНЕГ-ын 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг ИНЕГ-ын дарга баталж, ажилтнуудыг мэдээллээр хангах зорилгоор бүх нэгжид хүргүүлж, байгууллагын цахим хуудсанд байршуулсан. Төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийг байгууллагын цахим хуудсанд байршуулсан. <a href="https://www.mcaa.gov.mn/category/130">https://www.mcaa.gov.mn/category/130</a> Тус байгууллагаас 2023 онд авлигын эсрэг авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг "Flight" цахим сэтгүүлийн 12 дугаар сарын дугаарт нийтэлсэн.</p> <p>Хавсралт нийт : 7 Файл : 3 Зураг : 4</p>	
13	5.2.Авлигатай тэмцэх газраас дүрэм журам, ёс зүйн дүрмийн төсөлд өгсөн санал, зөвлөмжийг тусгасан байдал;	2023 он	-Санал тусгасан байх; -Тайланд нотломжийг хавсаргасан байх.	-	Иргэний нисэхийн ерөнхий газрын ажилтны ёс зүйн дүрмийн төслийг боловсруулж, АТГ-аас санал авч, ИНЕГ-ын даргын 2021 оны А/23 дугаар тушаалаар баталсан бөгөөд түүнээс хойш өөрчлөлт ороогүй байна. Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг 2023.03.31-04.07-ны өдрүүдэд тус газарт ажиллаж, тус газрын зардлаар оюутан суралцуулж буй байдалд хяналт, шалгалт хийж, ИНЕГ-ын даргын 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/658 дугаар тушаалаар баталсан "Иргэний нисэхийн чиглэлээр суралцуулах журам"-ыг хүчингүй болгож, Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд авч үзэх, шинэчлэн боловсруулж, АТГ-аас санал авч батлах зөвлөмж өгсөн. Үүний дагуу ИНЕГ-ын даргын 2022.09.29-ны өдрийн А/255 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Сургалтын асуудал хариуцсан байнгын зөвлөлийн бүрэлдэхүүн, журмыг ИНЕГ-ын даргын 2023.10.27-ны өдрийн А/317 дугаар тушаалаар хүчингүй болгосон."Иргэний нисэхийн ерөнхий газраас нисэхийн	100%	

						<p>чиглэлээр суралцуулах журам”-ыг шинэчлэн боловсруулж, 2023.05.26-ны өдрийн 01/868 дугаартай албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн. Журмыг дахин шинэчлэн боловсруулан, Авлигатай тэмцэх газраар хянуулж, баталгаажуулах арга хэмжээ авч өгөх хүсэлтийг 2023.06.23-ны өдрийн 01/1092 дугаартай албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн. ЗТХЯ журмын төсөлд санал авахаар 2023.10.27-ны өдрийн 05/5158 дугаартай бичгийг АТГ-т хүргүүлж, АТГ төслийг хянаж, саналаа 2023.11.09-ны өдрийн 04/18191 дугаартай албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн. ЗТХЯ-ны ТЗУГ нь АТГ-аас ирүүлсэн саналыг журамд тусгаж, Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар батлуулахаар ажиллаж байна. Тус байгууллагаас хамаарах ажил бүрэн хэрэгжсэн.</p> <p>Хавсралт : 3 файл</p>	
14	5.3.Удирдлага салбар, нэгж, байгууллагын хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр санаачлан хийх ажил, арга хэмжээг нэмж төлөвлөн, тайлагнах.	2023 он	-Төлөвлөгөөг баталж, олон нийт танилцах боломжоор хангасан байх; - khutulbur.iaас.mn цахим санд нэмж оруулсан байх, -Тайлагнасан байх.	-	<p>Тус газрын 2023 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний 5.3-д "Нийтийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангана" гэсэн заалтыг нэмж оруулж, хэрэгжилтийг хангаж тайлагнасан. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу байгууллагын цахим хуудсанд байршуулсан мэдээллийн байдалд дүн шинжилгээ хийж, 88 мэдээллийг байршуулах зохион байгуулалтын арга хэмжээ авсан.Цахим хөгжлийн яамны үнэлгээгээр тус байгууллагын шилэн нээлттэй ил тод байдал 93.1%-тай байна..<a href="https://shilen.gov.mn/">https://shilen.gov.mn/</a>. Мөн байгууллагын цахим хуудсыг шинэчилсэн. Мөн төлөвлөгөөнд тусгаагүй дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнд: 1.ХАСХОМ гаргах үүрэг бүхий албан тушаалд ажиллаж байгаа ажилтнуудад ашиг сонирхлын зөрчлөөс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж боловсруулж хүргүүлж, “Шударга ёс, хөгжил дэвшилд 110”</p>	100%	

						<p>мэдээллийн самбарт 9 сард байршуулсан.2.Тус байгууллагын хэмжээнд авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах 2 сургагч багшийг 2023.06.12-13-нд бэлтгүүлж, сургагч багшаар сургалт хийлгүүлж эхэлсэн. 3 Байгууллагын авлигын эрсдэлд үнэлгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, дунд хугацааны хөтөлбөрийг ИНЕГ-ын дарга 2023.11.08-ны өдөр А/386 дугаар тушаалаар баталсан.4.Ажилтнуудаас судалгаа авч, эрсдэлээ тодорхойлсон.</p> <p>Хавсралт нийт : 6 Файл : 3 Зураг : 3</p>	
Хэрэгжилт-95.1%							

ХЯНАСАН:  
ААДАА-НЫ ДАРГА

Б.МӨНХ-ОЧИР

БОЛОВСРУУЛСАН:  
ИНҮТ-ИЙН ЗХНГ-ЫН МЕНЕЖЕР

Д.СУВДАА